



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* Д.МӨНХ-ЭРДЭНЭ

**2021 ОНЫ ЭХНИЙ ХАГС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮНЭЛГЭЭТЭЙ ХОЛБОГДУУЛАН
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ДОТООД ХЯНАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**
2021.09.27

Нэг. Зорилго

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төлөвлөлт, албан хаагчдын албан хэрэг зохион бүрдүүлэлт, тайлангийн чанар, 2021 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, зөвлөмжийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг тооцож, дотоод хяналт хийх, зөвлөн туслах, илэрсэн зөрчлийг арилгах

Хоёр. Үндэслэл, хамрах хүрээ

Эрх зүйн үндэслэл:

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”

Дотоод хяналтын хамрах хүрээ: 2021 оны 3 дугаар улирлын байдлаар Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дагуу өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Хамрагдах албан хаагчид: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчид /үйлчлэгчээс бусад/ мэргэжилтнүүд

Гурав. Дотоод хяналт шалгалтын хугацаа

Хяналт, шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 06–09-ны өдөр

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хяналт шалгалтыг албан хаагч бүрт өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх
2. Ажлын байранд, цаасан болон цахим баримтад тулгуурлан гүйцэтгэнэ.
3. Хяналтын явц, үр дүнг нотлох баримт, фото зургаар баталгаажуулна.
4. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, зөвлөгөө, зөвлөмж өгөх, хугацаатай үүрэг даалгавар өгөх
5. Дотоод хяналт шалгалтын дүн, танилцуулгыг газрын даргад танилцуулж, мэдээллийг цахим хуудаст байршуулах

Тав. Дотоод хяналт, шалгалтын үр дүнг тайлагнах

Дотоод хяналт хийсэн тухай үнэлгээ, дүгнэлт, тайланг даргад 2021 оны 10 сарын 10-нд танилцуулна.

Дотоод хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавина.